



**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 18/002

Улаанбаатар хот

Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, Блю Скай Тауэрын Кристал танхимд болов.

Хурлын дарга: Өлзийбаярын ГАНЗОРИГ

Хурлын нарийн бичгийн дарга: Зоригтын ОДМАА

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 44

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 5,314,830 ширхэг

Хурлын ирц: 85.1 хувь буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Одмаа: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэлийг танилцуулав. Мөн Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2018 оны 11 сарын 5-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Хурлын дарга Ө.Ганзориг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулснаар хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Компанийн хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбогдон гарсан зардлын тайланг танилцуулах;

2 дугаар асуудал: Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус шинэ гишүүдийг томилох;

3 дугаар асуудал: Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалах үйл ажиллагааны цаг хугацааны дараалал, зөвлөх байгууллагын хамтын ажиллагаа, хувьцааны борлуулалтын үйл явц, анхдагч зах зээлийн арилжааны дүн, хувьцаан хуваарилалт, IPO хийхтэй холбоотой гарсан нийт зардал, хоёрдогч зах зээлийн арилжааны өнөөгийн нөхцөл байдал зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл хүргэв.

2 ДУГААР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 болон Компанийн дүрмийн 8.3-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүнийг сонгох үүрэгтэй. Энэ хүрээнд ТУЗ-д нэр дэвшигчдийн товч намтар, мэдээллийг танилцуулав. ТУЗ-ийн ердийн гишүүнд улируулан дэвшүүлж буй 4 гишүүн, шинээр дэвшүүлж буй 2 гишүүнийг танилцуулав.

Мандал Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлан 2018 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн “Өдрийн сонин”-ийн №202 (6045) дугаарт болон компанийн албан ёсны цахим хуудас болон Фэйсбүүк хуудсанд тус тус нийтэлснийг танилцуулан, нийт материал ирүүлсэн 6 нэр дэвшигчдээс ТУЗ хоёр гишүүнийг сонгосон болохыг танилцуулав. ТУЗ-ийн хараат бус гишүүнд улируулан дэвшүүлж буй 1 гишүүн, шинээр дэвшүүлж буй 2 гишүүн байв.

3 ДУГААР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг танилцуулав.

Тэмдэглэл:

1. *Хувьцаа эзэмшигч А.Базар:* Компанийн дүрмийн төслийн 5.2.9, 5.2.10, 16.11 дэх заалтуудаар Аудитын хяналт шалгалтыг энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч оруулах эрхтэй болохыг заасан байна. Энэ зүйл заалт нь жижиг хувьцаа эзэмшигч нарын ашиг сонирхлыг хангаж байгаа гэж үзэж байна уу? Энэ хувь хэмжээг бууруулахгүй юу? Энэ “10 хувь” гэдэг нь зөвхөн нэг хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувь хэмжээ юу, эсвэл жижиг хувьцаа эзэмшигчид нийлээд эзэмшиж буй хувиа 10 хувь болгох боломжтой гэсэн үг юу?

Мандал Даатгал ХК-ийн эрх зүйн нийцлийн менежер Э.Удвал: 10 хувь гэж тогтоож өгсөн нь Компанийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны үлгэрчилсэн загварын дагуу тогтоосон агуулга байгаа.

Хурлын дарга Ө.Ганзориг: Жижиг хувьцаа эзэмшигч нар нийлээд компанийг шалгуулах эрх бол нээлттэй байгаа. 10 хувь гэдэг заалт 5 хувь болтол бууж болох эсэхийг дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хөндөж болно. Энэ хувь хэмжээ хэтэрхий бага байвал компанийг ажил хийлгэдэггүй гэсэн асуудал үүсэх эрсдэлтэй, хэтэрхий том байвал жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх хөндөгддөг учраас голын уулзах цэгийг нь олох шаардлагатай.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга П.Оргодол

Танилцуулгын гол агуулга: Кумулятив аргаар ердийн болон хараат бус гишүүнийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

2 ДУГААР АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Ө.Ганзориг	нийт санал өгөх эрх	37,458,096
	санал өгсөн эрх	5,076,711
	хувь	13.55%
Н.Монсор	нийт санал өгөх эрх	37,458,096
	санал өгсөн эрх	5,025,923
	хувь	13.42%
О.Ганжолоо	нийт санал өгөх эрх	37,458,096
	санал өгсөн эрх	5,025,819
	хувь	13.42%
А.Амундра	нийт санал өгөх эрх	37,458,096
	санал өгсөн эрх	4,993,002
	хувь	13.33%
Ч.Ванчин-Эрдэнэ	нийт санал өгөх эрх	37,458,096
	санал өгсөн эрх	6,635,667
	хувь	17.71%

Б.Жавхлан	нийт санал өгөх эрх	37,458,096
	санал өгсөн эрх	5,059,112
	хувь	13.51%

Үүнээс Ө.Ганзориг, Н.Монсор, О.Ганжолоо, А.Амундра, Ч.Ванчин-Эрдэнэ, Б.Жавхлан нар сонгогдов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Жеймс Бернард Двайер	нийт санал өгөх эрх	18,729,048
	санал өгсөн эрх	5,043,465
	хувь	26.93%
Ж.Дэлгэрсайхан	нийт санал өгөх эрх	18,729,048
	санал өгсөн эрх	5,011,885
	хувь	26.76%
Н.Мандуул	нийт санал өгөх эрх	18,729,048
	санал өгсөн эрх	5,850,124
	хувь	31.24%

Үүнээс Жеймс Бернард Двайер, Ж.Дэлгэрсайхан, Н.Мандуул нар сонгогдов.

3 ДУГААР АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.8 хувь нь зөвшөөрсөн санал өгсөн.

Хурлын дарга Ө.Ганзориг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарч буй тогтоолын төслийг уншиж танилцуулж, хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 13:00 цагт хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

З.ОДМАА

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ТАНИЛЦСАН

Ө.ГАНЗОРИГ
Хурлын дарга